



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/147/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2024 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	12
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.19 № 53
танай _____-ны № _____-т

УРГАМАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ӨСӨХБАЯР-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлангийн уялдааг 268,000 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг 237,460 төгрөгөөр илүү тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй 15,741,825.48 төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитын гол асуудал

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс "Залуучуудын SDY-cup" спортын наадамд оролцогчдын халаалтын хувцас, хоол, байр, шатахуунд 4,000,200 төгрөгийн, сум, орон нутгийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа явуулах зорилготой 3,500,000 төгрөгийн шатахууны зардал гарган Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот руу явсан ажлын тайлан байхгүй, үр дүн гараагүй, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэр гаргасан

ажлын хэрэгжилтийг хангахаар 1,000,000 төгрөгийн шатахуун олгож, үрэлгэн зардал гаргасан зэрэг нийт 8,500,200 төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Ургамал сумын Засаг даргын Тамгын газарт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 29,900,000 төгрөгийн Баян-Улаан багийн байр, 39,100,000 төгрөгийн дуф машин, 15,000,000 төгрөгийн Хульж багийн хадлангийн хайс, 19,885,800 төгрөгийн мал нядалгааны байрны худаг зэргийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ төгрөгөөр /
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,309,334.48	34,567,414.48
35	БАРАА МАТЕРИАЛ	31,309,334.48	34,567,414.48
35400	Хангамжийн материал	31,309,334.48	34,567,414.48
35410	Бичиг хэргийн материал	2,299,205.00	3,540,945.00
35420	Аж ахуйн материал	25,492,329.48	25,611,379.48
35430	Сэлбэг хэрэгсэл	1,290,000.00	558,000.00
35440	Түлш, шатах тослох материал	35,700.00	2,319,990.00
35450	Барилгын засварын материал	2,192,100.00	2,537,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,668,068,334.79	1,731,523,838.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,668,068,334.79	1,731,523,838.49
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	1,664,407,834.79	1,728,193,338.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,028,225,484.00	2,058,125,484.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-525,462,145.38	-600,385,103.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,959,800.00	154,059,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,424,952.16	-87,078,847.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	282,164,792.66	285,621,393.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-204,406,685.75	-214,627,503.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,378,367.20	18,043,468.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,814,672.45	-15,616,697.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	124,346,250.15	189,648,239.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	-65,047,103.48	-67,085,594.14
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0	0
39217	Ном	1,488,700.00	7,488,700.00
39300	Биет бус хөрөнгө	3,660,500.00	3,330,500.00
39301	Программ хангамж	2,802,000.00	2,802,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,839,500.00	-2,169,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,698,000.00	2,698,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,699,377,669.27	1,766,091,252.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	46,479,778.00	3,955,850.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	46,479,778.00	3,955,850.00
41300	Өглөг	46,479,778.00	3,955,850.00
41360	Бусад өглөг	46,479,778.00	3,955,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	42,879,778.00	3,955,850.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,600,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,652,897,891.27	1,762,135,402.97
51	Засгийн газрын хувь оролцоо	1,652,897,891.27	1,762,135,402.97
51100	Засгийн газрын оруулсан капитал	359,126,865.33	359,126,865.33
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	359,126,865.33	359,126,865.33
51200	Хуримтлагдсан үр дүн	1,107,819,758.05	1,219,313,568.75
51210	Өмнөх үеийн үр дүн	-326,329,798.53	1,110,076,057.05
51220	Тайлант үеийн үр дүн	1,434,149,556.58	109,237,511.70
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	185,951,267.89	183,694,968.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,699,377,669.27	1,766,091,252.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,976,987,464.42	165,164,226.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,548,185,005.42	162,825,369.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,548,185,005.42	162,825,369.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	3,145,379.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	3,145,379.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,548,185,005.42	159,679,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,802,459.00	2,338,857.70
131009	Хаагдсан данс	0	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,685,359.00	2,338,857.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,685,359.00	2,338,857.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,117,100.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,117,100.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,837,907.84	595,080,948.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,837,907.84	595,080,948.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,267,365.84	594,857,889.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,941,088.00	329,872,618.56
210101	Үндсэн цалин	213,203,647.00	223,936,265.56
210102	Нэмэгдэл	0	69,922,395.00
210104	Урамшуулал	0	36,013,958.00
210105	Гэрээт ажлын хөлс	737,441.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,818,175.38	40,120,126.00
210201	Тэтгэврийн даатгал	18,446,497.73	26,840,390.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,143,312.90	3,323,404.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,714,650.31	2,971,789.42
210204	Ажилгүйдлийн даатгал	410,337.47	629,801.73
210205	Эрүүл мэндийн даатгал	4,103,376.97	6,354,740.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,968,426.00	68,871,510.96
210301	Гэрэл, цахилгаан	4,878,648.00	6,138,626.61
210302	Түлш, халаалт	80,089,778.00	62,732,884.35
2104	Хангамж, бараа материалын зардал	25,406,294.50	33,958,294.70
210401	Бичиг хэрэг	1,556,820.00	2,218,457.00
210402	Тээвэр, шатахуун	17,449,274.50	27,199,517.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,278,500.00	2,286,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,121,700.00	2,040,820.00
210408	Бараа материал акталсны зардал	0	213,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	961,000.00	1,387,000.00
210604	Урсгал засвар	961,000.00	1,387,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,846,100.00	4,073,900.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	5,846,100.00	4,073,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,550,700.00	1,332,871.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,376,700.00	299,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	302,300.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,500.00	128,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	506,800.00
210807	Газрын төлбөр	138,300.00	95,821.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,775,581.96	115,241,568.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,620,550.00	19,017,082.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,155,031.96	96,224,486.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,570,542.00	223,059.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,640,800.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,640,800.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,929,742.00	223,059.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,678,400.00	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	251,342.00	223,059.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,434,149,556.58	-429,916,721.82
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,434,149,556.58	-429,916,721.82

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/ төгрөгөөр /</i>			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	434,108,661.50	560,157,236.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	0
120009	Бусад орлого	300,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	433,808,661.50	5,484,236.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,691,561.50	5,484,236.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,691,561.50	5,484,236.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,117,100.00	554,673,000
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,117,100.00	554,673,000
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,508,661.50	544,638,470.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,508,661.50	544,638,470.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,043,119.50	544,415,411.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,683,000.00	324,590,936.00
210101	Үндсэн цалин	170,113,123.00	218,766,749.00
210102	Нэмэгдэл	34,266,649.00	74,083,539.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	9,303,228.00	31,740,648.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	0
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,059,258.00	41,445,958.56
210201	Тэтгэврийн даатгал	20,735,544.63	28,179,187.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,063,189.00	3,323,404.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,669,506.33	2,848,089.42
210204	Ажилгүйдлийн даатгал	417,401.59	629,801.73
210205	Эрүүл мэндийн даатгал	4,173,616.45	6,465,476.13
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0	0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,372,900.00	113,219,938.96
210301	Гэрэл, цахилгаан	4,162,900.00	6,084,128.81
210302	Түлш, халаалт	37,210,000.00	107,135,810.15
210303	Цэвэр, бохир ус	0	0
210304	Байрны түрээс	0	0
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0	0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,715,300.00	19,114,776.70
210401	Бичиг хэрэг	1,226,600.00	3,460,197.00
210402	Тээвэр, шатахуун	9,832,650.00	13,368,079.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,656,050.00	2,286,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	910,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	910,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,676,900.00	7,673,900.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	2,676,900.00	7,673,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,054,361.50	3,202,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,845,361.50	2,472,320.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	302,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	128,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,000.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	95,821.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,571,400.00	34,167,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,395,100.00	33,864,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	176,300.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,465,542.00	223,059.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,535,800.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,835,800.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,929,742.00	223,059.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,678,400.00	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	251,342.00	223,059.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,600,000.00	-539,154,233.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,600,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,600,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	13,600,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,600,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,600,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	-539,154,233.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	359,126,865.33	185,951,267.89	-325,898,998.53	219,179,134.69
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	359,126,865.33	185,951,267.89	1,107,819,758.05	1,652,897,891.27
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	359,126,865.33	185,951,267.89	-326,329,798.53	218,748,334.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-430,800.00	-430,800.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	1,434,149,556.58	1,434,149,556.58
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	359,126,865.33	185,951,267.89	1,107,819,758.05	1,652,897,891.27
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	359,126,865.33	183,694,968.89	1,219,313,568.75	1,762,135,402.97
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	359,126,865.33	183,694,968.89	1,110,076,057.05	1,652,897,891.27
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	-2,256,299.00	2,256,299.00	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	109,237,511.70	109,237,511.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,048,000.00	539,154,233.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,048,000.00	539,154,233.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,048,000.00	539,154,233.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,043,800.00	324,590,936.00
210101	Үндсэн цалин	240,325,100.00	218,766,749.00
210102	Нэмэгдэл	96,718,700.00	74,083,539.00
210104	Урамшуулал	0	31,740,648.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,130,600.00	41,445,958.56
210201	Тэтгэврийн даатгал	28,648,700.00	28,179,187.18
210202	Тэтгэмжийн даатгал	3,370,500.00	3,323,404.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,696,400.00	2,848,089.42
210204	Ажилгүйдлийн даатгал	674,100.00	629,801.73
210205	Эрүүл мэндийн даатгал	6,740,900.00	6,465,476.13

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,558,300.00	112,519,938.96
210301	Гэрэл, цахилгаан	4,776,900.00	5,384,128.81
210302	Түлш, халаалт	107,781,400.00	107,135,810.15
2104	Хангамж, бараа материалын зардал	18,085,000.00	18,082,997.00
210401	Бичиг хэрэг	2,632,900.00	3,460,197.00
210402	Тээвэр, шатахуун	12,336,300.00	12,336,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,115,800.00	2,286,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,953,900.00	6,953,900.00
210702	Дотоод албан томилолт	6,953,900.00	6,953,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,888,000.00	730,021.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	302,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	128,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	95,821.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,388,400.00	33,830,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,085,000.00	33,527,082.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575,048,000.00	539,154,233.52
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	530,048,000.00	539,154,233.52
320001	Орон нутгийн төсвөөс	530,048,000.00	539,154,233.52
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,000,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	45,000,000.00	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,484,236.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,484,236.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,261,177.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	700,000.00
210301	Гэрэл, цахилгаан	700,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	1,031,779.70
210402	Тээвэр, шатахуун	1,031,779.70
2107	Томилолт, зочны зардал	720,000.00
210702	Дотоод албан томилолт	720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,472,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,472,320.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	337,078.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	337,078.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,059.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,059.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	223,059.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,484,236.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,484,236.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,484,236.70

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ургамал сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ шудрага, соёлыг эрхэмлэж, ил тод, ижил тэгш нээлттэй хөнгөн шуурхай хүргэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 134 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 90.4 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ургамал сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,713.6 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	31,309.3	34,567.4	3,258.1
Үндсэн хөрөнгө	1,668,068.3	1,731,523.8	63,455.5
Нийт хөрөнгө	1,699,377.6	1,766,091.2	66,713.6
Өр төлбөр	46,479.8	3,955.8	(42,524.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,652,897.8	1,762,135.4	109,237.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,699,377.6	1,766,091.2	66,713.6

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материалын эхний үлдэгдэл 31,309.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 37,729.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 34471.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 34,567.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,258.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн хувьд хөрөнгө оруулалтаар 159,680.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, шийдвэрийн дагуу 2,256.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж,

жилийн эцэст 2,718,487.1 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 96,224.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 109,237.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 445,099.7 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 45,000.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт 400,099.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 129,948.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 5 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 45,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 530,048.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 554,673.0 мянган төгрөгийн санхүүжилт, олгож, гүйцэтгэл 539,154.2 мянган төгрөг буюу 97.2 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 15,518.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	432,115.9	430,031.5	2,084.4	99.5
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	87,647.1	75,595.6	12,051.5	86.2
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	0.0	1,200.0	0.0
4	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	50,000.0	33,527.1	16,472.9	67.1
5	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	4,085.0	0.0	4,085.0	0.0
		Дүн	575,048.0	539,154.2	35,893.8	93.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 5,484.2 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газраас 1,838.2 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 500.6 мянган төгрөг, өөрийн орлого 3,145.4 мянган төгрөгөөс тус тус бүрдсэн байна. Үүнийг өвс тэжээл хүргэх шатахуун, малын түүвэр судалгааны шатахуун, хамтарсан багийн зардал, сургалт, томилолт зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 223.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	-	-	-	-
ДҮН			-	-

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 3/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогын 719,837.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,797.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,558.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулган шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тухай бүр оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 131,244.7 мянган төгрөгийн зөрчилд 4 заалт зөвлөмж, 7,383.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг тус тус 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,102.5	2	1,102.5	
Албан шаардлага	4	63,584.5	4	63,584.5	100
Зөвлөмж					
Нийт дүн	6	64,687.0	6	64,687.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,247.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 16,247.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Санхүүгийн тайлангийн уялдааг зөрүүтэй илэрхийлсэн 268.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын тайлангийн цалин хөлсийг 237.4 мянган төгрөгөөр илүү тусгасан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй 15,741.8 мянган төгрөгийн алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 8,500.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,500.2 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

- Засаг даргын нөөц хөрөнгөөс "Залуучуудын SDY-cup" спортын наадамд оролцсон хүмүүсийн халаалтын хувцас, хоол, байр, шатахуунд 4,000.2 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан;

- Сум, орон нутгийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа явуулах зорилготой 3,500.0 мянган төгрөгийн шатахууны зардал гарган Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот руу явсан ажлын тайлан байхгүй, үр дүн гараагүй;

- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэр гаргасан ажлын хэрэгжилтийг хангахаар 1,000.0 мянган төгрөгийн шатахуун олгож, үрэлгэн зардал гаргасан байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн уялдааг зөрүүтэй илэрхийлсэн	1	268.00			1	268.00	1	268	0	0		
Нийгмийн даатгалын тайлангийн цалин хөлсийг 237.4 мянган төгрөгөөр илүү тусгасан	1	237.40			1	237.40	1	237.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй	1	15,741.80			1	15,741.80	1	15741.8				
Дүн	3	16,247.20	0	-	3	16,247.20	3	16,247.20	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийлжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс "Залуучуудын SDY-сир" спортын наадамд оролцсон хүмүүсийн халаалтын хувцас, хоол, байр, шатахуунд 4,000.2 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан	1	4000.2			1	4,000.20	0	-				
Сум, орон нутгийг сурталчилан таниулах, сургалт сурталчилгаа явуулах зорилготой 3,500.0 мянган төгрөгийн шатахууны зардал гарган Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот руу явсан ажлын тайлан байхгүй, үр дүн гараагүй	1	3,500.00			1	3,500.00	0	-				
Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэр гаргасан ажлын хэрэгжилтийг хангахаар 1,000.0 мянган төгрөгийн шатахуун олгож, үрэлгэн зардал гаргасан	1	1,000.00			1	1,000.00	0	-				
Дүн	3	8,500.20	0	-	3.00	8,500.20	0	-	0	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2024.02.22

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

2024.02.22

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

2024.02.22